

**МОНГОЛ ХЭЛНИЙ НЭР ҮГИЙН ХЭЛЗҮЙН
ТООНЫ АЙН ИЛРЭХ АРГА, ХЭРЭГЛҮҮР**

Г. Буянтогтох¹

Монгол хэлээр тооны харилцаа илрэхдээ юуны өмнө тодорхой, тодорхой бусын эсрэгцэлд тулгуурладаг байна. Ер нь аливаа хэлний тооны айг тодорхой тодорхой бус гэж ангилаад, тус бүрийн дотор ганц ба олны эсрэгцэл гарган харьцуулж тайлбарлах уламжлал хэлшинжлэлийн ухаанд уламжлан тогтоод хэдэн үеийг улираажээ.

Монгол хэлний тооны айн тухайд тодорхой тодорхой бусын айгаар илэрч, тодорхой тоо нь ганц тоо, ганц бус тооноос бүрдэх ба ганц бус тоог дотор нь ганц бус цөөн тоо, ганц бус олон тоо хэмээн ялгардаг байна. Тухайлбал, *нэг хүү, ганц охин* гэх мэт жишээний *хүү, охин* зэрэг үг ганц тоот нэр бөгөөд тэрхүү ганц тоог нь *нэг, ганц*, гэдэг үг заан илрүүлж байна. Хэрэв *хоёр хүү, гурван охин* гэвэл тодорхой, ганц бус тоот нэр болно. Тодорхой ганц бус тоо дотроо олон, цөөний эсрэгцлээр дамжин илэрнэ. Тухайлбал, *хос загас, мянгахан цэрэг* гэх мэт жишээ тодорхой ганц бус цөөн тоот нэр бөгөөд ер нь юмын олон цөөн нь мэдэгдэхүүний талаас бодтой, мэдэхүүний талаасаа харьцангуй юм. Түүнчлэн, "Хүн ирлээ", "Би номтой" гэвэл тэрхүү хүн, ном нь олон тоотой болж байгаа юм уу, эсхүл ганц тоотой болж байгаа юм уу? Үүнд, түүнийг хоёр талаас авч үзэж болно. Юуны өмнө өгүүлэгч этгээдийн хувьд бол тэр нь ганц, эсхүл олон гэдэг нь тодорхой ялгаатай байх ёстой байна. Тодорхой ганц бус тоот юмын тооны олон цөөний ай илрэх нь мэдэхүүний тал буюу харилцааны тухайн орчинд өгүүлэгч уул юмыг хэрхэн үзэж, үнэлж цэгнэж байгаагаас ихээхэн шалтгаалдаг байна. Харин юмын тодорхой, ганц бус тоог бодтойгоор заах тохиолдол ч харилцаанд элбэг бөгөөд түүнийг ерийн тоо буюу ялгаваргүй тоо; бодтой бус, өгүүлэгчийн хувийн үзэмж үнэлэмжээр илэрч буй тоог ерийн бус буюу ялгаварт тоо хэмээн нэрлэж болно. Монгол хэлэнд хэлзүйн арга, хэлний хэрэглүүрээр дамжин илэрч байгаа тодорхой тооны утгыг *Нэг ном, Ганц ном* гэх мэт тодорхой ганц тоо; *Арван мор, Гурван түмэн адуу* гэх мэт тодорхой, ганц бус, ялгаварт бус тоо; *Аравхан морь, Түм төдий цэрэг* гэх мэт тодорхой, ганц бус, ялгаварт цөөн тоо; *Арван түмэн их цэрэг, Гурван зуун олон шавь нар* гэх мэт тодорхой, ганц бус, ялгаварт, олон тоо гэж ялган хэлэлцэж болно.

Монгол хэлний хэлзүйн тодорхойгүй тооны ай ганц, ганц бусаар эсрэгцэн илэрдэггүй бөгөөд энэ онцлог зөвхөн монгол хэлэнд хамаатай төдийгүй, ерөөс дэлхийн аль ч хэлэнд тодорхойгүй ганц тоо, ганц бус тооны ай гэж байхгүй. Учир нь, бодит байдлын ганц, ганц бусын ухагдахуун ямагт тодорхой утгаар илрэхээс биш багцаалан тоймлосон тоон утгад хамаарах боломжгүй юм.

¹ Доктор, дэд профессор. МУИС-ийн Монгол хэл, соёлын сургууль.

Монгол хэлний хэлзүйн тодорхойгүй тооны ай олон, цөөний эсрэгцэлд тулгуурлан илрэх нь ялгаварт тоо болох бөгөөд үүний нөгөө талд ялгаваргүй, тодорхой бус тоо байж, тодорхойгүй тооны ай сая жинхнээр бүрдэн боджиж хэлзүйн ай болдог зүйтогтолтой юм. Үүнд, Оруулах газар цөөн, нэг хэдэн хүн иржээ, Ирсэн хүн маш олон, Хэдэн арван малчин гэх мэт тодорхойгүй ялгаварт тоо; Мянга зургаан зуу гаруй жилийн өмнө, Их буугийн сум арав хориод гэх мэт тодорхойгүй, ялгаварт бус тоо болно.

Монгол хэлний тодорхойгүй, ялгаварт тоог олон, цөөний эсрэгцлээр ялган хэлэлцэхдээ Өчнөөн жил, Үлэмж мөнгө гэх мэт тодорхойгүй, олны ялгаварт тоо; Оруулах газар цөөн, Хэдхэн хүн иржээ гэх мэт тодорхойгүй, цөөний ялгаварт тоо хэмээн ангилж болно. Монгол хэлний дээр дурдсан тодорхой, тодорхойгүй, ганц, ганц бус, ялгаварт, ялгаварт бус тооны ай монгол хэлний төрлийн нэр, хэсгийн нэрийн аль алинд нь хамаатай боловч тооны харилцаа илтгэхэд эдгээр хэлнээ төрлийн нэрийг түлхүү хэрэглэдэг онцлогтой байна.

Монгол хэлний хэсгийн нэрээр илрэх хэлзүйн тооны утгыг Нэг баг морин цэрэг, Нэг өрх хүн гэх мэт тодорхой, ганц тоо; Хоёр хос гутал, Хорин найман залуус гэх мэт тодорхой, ганц бус тоо хэмээн ангилж болох бөгөөд сүүлчийнхийг харилцааны орчин, өгүүлэгчийн хандлага буюу баймжид тулгуурлан, Гурван мянган олон шавь нарын дотор далан хоёр эрдэмт хүн байжээ, Арван сүрэг олон үхэр гэх мэт тодорхой, ганц бус, олны ялгаварт тоо; Дөрөвхөн хос гутал байна, Зуухан өрх хүн гэх мэт тодорхой, ганц бус, цөөний ялгаварт тоо; Гурвуул гэртээ оров, Энэ бодлогын хариу гучин дөрөв, Нас нь хорин тав гэх мэт тодорхой, ганц бус, ялгаваргүй тоо гэж болно. Түүнчлэн, Хэдэн өрх хүн, Хэд хэдэн орд од, Тоогүй олон хүмүүс, Өчнөөн олон сүрэг үхэр, Зуугаад баг морин цэрэг, Хоёр зуугаад багц зүү, Мянгаад жил, Хэдхэн орд од, Хэдхэн азарга адуу гэх мэт тодорхойгүй тоо гээд, үүнийг цаашид Хэд хэдэн орд од, Тоогүй олон хүмүүс, Өчнөөн олон сүрэг үхэр гэх мэт тодорхойгүй, олны ялгаварт тоо; Хэдхэн орд од - мо: Хэдхэн азарга адуу гэх мэт тодорхойгүй, цөөний ялгаварт тоо; Зуугаад баг морин цэрэг, Хоёр зуугаад багц зүү, Мянгаад жил гэх мэт тодорхойгүй, ялгаварт бус тоо хэмээн ангилж болно.

Монгол хэлний нэр үгэлбэрийн хэлзүйн тооны ай тодорхой, тодорхой бус; тодорхой нь ганц, ганц бус; тодорхойгүй нь ялгаварт ба ялгаварт бус; тодорхой ганц бус нь ялгаварт, ялгаварт бус; тодорхой ялгаварт ба тодорхой бус ялгаварт нь олон цөөний эсрэгцэлд тус тус тулгуурлан илрэхдээ хэлзүйн арга болон хэлний хэрэглүүрийн хувьд доорхи байдалтай байна. Үүнд,

1.Бүтээврээр илрэх байдал

Монгол хэлний нэр үгэлбэрийн хэлзүйн тооны ай илрэх хэрэглүүрийн нэг болсон бүтээврийг дагавар, нөхцөл гэж хоёр ангилаад, цаашид тэдгээрийг тус тусад нь нэр үгэлбэрийн дагавар, үйл үгэлбэрийн дагавар; нэр үгэлбэрийн нөхцөл, үйл үгэлбэрийн нөхцөл гэж ангилж болно. Үүнд, Арав + т, зуу + т, зурав + т гэх мэтээр тооны нэрийн үндсэнд залгаж тодорхой тоотыг илтгэсэн нэр үг үүсгэх -т дагавраар буюу нийлэг аргаар хэлзүйн тооны айн утга илтгэж байна. Түүнчлэн, үндсэн тооны нэрээс хам тоо үүсгэх -уул, -үүл; тойм тоо үүсгэх -аад, -ээд, -оод, -өөд; дэс тоо үүсгэх -дугаар, -дүгээр, -дахь, -дэхь; дахих тоо үүсгэх -таа, -тээ, -тоо, -төө дагавраар тодорхой ба тодорхой бус тооны утгат үгэлбэр үүсгэн, түүнийг нэр үгэлбэр, үйл үгэлбэрийн аль зохилдох

нэгэнд захируулж, нэрийн тооны айн утгыг задлаг аргаар илтгэдэг байна. Тодруулбал, дэс тоо үүсгэх дагавар ямагт тодорхой, тойм тоо үүсгэх дагавар ямагт тодорхойгүй тоотын утга илтгэдэг бол хам тоо, дахих тоо үүсгэх дагавар харилцааны нэг орчинд тодорхой тоо, нөгөө орчинд тодорхойгүй тооны утга илтгэх боломжтой юм. Тухайлбал, гурвуул; зургуул; гурвантаа; зургаантаа гэвэл тодорхой тоо; олуул; цөөхүүл гэвэл тодорхойгүй тооны утга илтгэнэ. Эдгээрээс гадна үйл үндсэнд залгаж нэр үг үүсгэдэг -л, -мал, -мэл, -мол, -мөл, -с, -р, -бар, -бэр, -бор, -бөр, -вар, -вэр, -вор, -вөр, -аа, -ээ, -оо, -өө зэрэг дагавар байгаа бөгөөд ийм дагавартай нэр үгэлбэр тодорхойгүй ганц бус тоотын утгыг нийлэг аргаар илтгэдэг. Жишээлбэл, нэгдэл; нийлмэл; холбоо; залгаас; бэлчир; уулзвар; нийлбэр гэх мэт.

Монгол хэлний нэр үгэлбэрийн хэлзүйн тооны айн утгыг голдуу нийлэг аргаар илтгэх үйл үг -л, -с, -р, -ч, -ц, -ж, -з, -в, -шир, -на, -нэ, -но, -нө, -ни, -би, -ш гэх мэт дагаврын тусламжтайгаар үүсэх бөгөөд ингэж үүссэн үйл үг үгэлбэр болохдоо хэлзүйн тодорхой, тодорхойгүй тооны утга илтгэнэ. Үүнд, зуравла, тавла, долоол, аравла гэх мэт үгэлбэр тодорхой тооны утга илтгэх бөгөөд ямагт хоёр гэсэн тодорхой тооны утга илтгэдэг хос гэдэг үгнээс үйл үг бүтээх дагаврын тусламжтайгаар хосол гэж тодорхой тоотын утга илтгэх үйл үг үүсгэдэг байна.

Олшир; цөөр; хор; нэм; хас; сийр; салаал; нийл; эсрэг; мөрийц; үрж; сарни; цувар; түг гэх мэт нэлээд үйл үгэлбэр харилцааны ердийн орчинд буюу тодорхой тоотын утга илтгэх тусгай тодотгол аваагүй үедээ тодорхойгүй тооны утга илтгэнэ. Гэтэл, хориш гэдэг үгэлбэр шууд утгаараа байхдаа ямагт тодорхой тоо заах ба харилцааны орчин өөрчлөгдвөл олуул хориших гэх мэтээр тодорхойгүй тооны утга илтгэнэ.

Монгол хэлний нэр үгэлбэрийн хэлзүйн тооны айн илрэх хэрэглүүр болох нөхцөлийг захируулах нөхцөл, хамаатуулах нөхцөл гэж хоёр хуваана. Үүнд, -д, -т, -ыг, -ийг, -г, -аас, -ээс, -оос, -өөс, -аар, -ээр, -оор, -өөр, -тай, -тэй, -той гэх мэт нь захируулах айн нөхцөл; -минь, -маань, -чинь, -тань, -тэнь, -ын, -ийн, -ы, -ий, -н зэрэг нь хамаатуулах айн нөхцөл болно.

Нэрийн захируулах нөхцөл тооны нэр болон тооны утга илтгэх үгэлбэрийг үйл үгэнд захируулж, хэлзүйн тодорхой ба тодорхойгүй тооны айн утгыг задлаг аргаар илтгэнэ. Жишээлбэл, Гурваас доош; зугаас дээш гэвэл тодорхойгүй тоо, зургаа зургаагаар жагсах; наймд хуваах гэвэл тодорхой тоо тус тус илтгэх бөгөөд харилцааны тухайн орчинд ялгаварт, ялгаварт бус, ганц, ганц бус тоог заана.

Нэрийн хамаатуулах нөхцөл гурван биеийг ганц, ганц бус тоогоор ялган, тухайн юм үзэгдэл аль биеийн ямар тоотод хамаатаж буйг заах ба ингэхдээ нэр үгэлбэрийн хэлзүйн тооны айн утгыг нийлэг аргаар илтгэнэ. Жишээлбэл, Ном минь гэвэл нэгдүгээр биеийн ганц эзний ном гэсэн утга; Ном маань гэвэл нэгдүгээр биеийн ганц бус эзний ном гэсэн утга илтгэнэ. Өөрөөр хэлбэл, нэрийн хамаатуулах нөхцөл тухайн юмын тоог бус, харин түүнийг харъяалж буй эзний тодорхой, тодорхойгүй тоог харилцааны янз бүрийн орчинд тохируулан илтгэх үүрэгтэй байна. Үүнд, -минь, -чинь нөхцөл ямагт ганц эзэнд, -маань нөхцөл ямагт ганц бус эзэнд хамаатуулна. Жишээ, Морь минь; гэр чинь; ах тань; ах (и)нь; ах нар маань; морьд тань; морьд (а)нь гэх мэт. Харин -тань, -тэнь нөхцөл заримдаа ганц эзэнд, заримдаа ганц бус эзэнд хамаатахын утга илтгэнэ. Учир нь, эдгээр нөхцөлтэй үг биеийн төлөөний үггүй дангаар байхдаа дэвтэр тэнь - дэвтрүүд тэнь гэх мэтээр нэг биед хамаатуулж байгаа, хэсэг хүнд хамаатуулж

байгаа нь үл ялгарна. Гэтэл таны дэвтэр тэнь, таны дэвтрүүд тэнь, танай дэвтэр тэнь, танай дэвтрүүд тэнь гэвэл нэг хүнд хамаатай юм уу, нэг бус хүнд хамаатай юм уу гэдэг сая тодорхой болно. Мөн, сэтгүүл нь, сэтгүүлүүд нь гэвэл ганц, ганц бус эзний алинд хамаатуулж байгаа нь үл мэдэгдэнэ. Харин, сэтгүүл (и)нь, сэтгүүлүүд (и)нь гэвэл ганц эзэнд хамаатай, сэтгүүл (а)нь, сэтгүүлүүд (а)нь гэвэл ганц бус эзэнд хамаатай нь тодорхой болно. Үүнд, орчин цагийн монгол хэлнээ орос үсгээр нь гэж тэмдэглэж байгаа гуравдугаар биеийн хамаатуулах нөхцөлийг монгол бичигт -ину, -ину; -ану гэж тэмдэглэн, ганц эзэнд хамаатуулахад -ину, -ину, ганц бус эзэнд хамаатуулахад -ану хэрэглэдэг дүрэмтэй. Энэ дүрэм монголоор зөв харилцах ёсонд бүрэн нийцсэн боловч, монгол үгийг орос үсгээр тэмдэглэхээр болгоход энэ онцлогийг тусгаагүйгээс хэдэн эзэнд хамаатуулж байгааг нь ялгахад заавал тусгай үгээр тодотгох юм уу нэмэлт тайлбар дагалдуулах шаардлагатай болжээ. Тийм учраас дээрх жишээнд (а)нь, (и)нь гэж тэмдэглэлээ.

Монгол хэлний нэр үгэлбэрийн хэлзүйн тооны айг илтгэх залгаврын буюу нийлэг аргын нэг чухал хэсэг нь -лд, -лц гэх мэт үйл үгэлбэрийн хэвийн нөхцөл бөгөөд эдгээр нөхцөлөөр хувилсан үгэлбэр ердийн харилцаанд танилц, шуугилд, ярилц гэх зэргээр тодорхойгүй ганц бус тооны утга илтгэдэг. Хэрэв харилцааны орчин өөрчлөгдөж, тодорхой, ялгаварт тоо шаардвал тэр тухайд тооны нэр болон тоо заах үгэлбэр, бусад холбогдох үгэлбэрийг эдгээр нөхцөлөөр хувилсан үйл үгэлбэрт захируулан холбож, шаардлагатай тооны утгыг илтгэнэ. Жишээлбэл, Бид хоёр багштай ярилцав гэвэл тодорхой ганц бус, ялгаварт бус тоо; Тэд жимс түүлцэв гэвэл тодорхойгүй, ганц бус, ялгаварт бус тоо; Тэр гурав жимс түүлцэв гэвэл тодорхой, ганц бус ялгаварт бус тоо тус тус илтгэнэ. Сүүлийн жишээнд байгаагчлан, тодорхой тоо заах үгтэй хавсарсан үед нэр үгэлбэрийн хэлзүйн тооны айн утгыг задлаг-нийлэг аргаар илтгэдэг.

Хэлзүйн тооны айн утга илтгэхэд үйл үгэлбэрийн хэвийн нөхцөлөөс гадна зарим байдлын нөхцөл, тухайлбал, -цгаа, -цгээ, -цгоо, -цгөө зэрэг залгавар бүтээвэр идэвхтэй оролцож, харилцааны ердийн орчинд тодорхойгүй ганц бус, ялгаварт бус тооны утга илтгэнэ. Жишээлбэл, Бид явцгаая; Та нар очигцоо; Тэд ирцгээв гэх мэт.

Харин, шаардлагатай үед бол Тавын тавуулаа явцгаалаа; Та нар гурвуулхнаа очигцоо; Тэр долоо л ирцгээг гэх мэтээр тодорхой, ялгаварт тооны утгыг заана. Ингэхдээ тоо заах үгэлбэр болон ганц, ганц бусыг ялгах үгэлбэртэй бол задлаг-нийлэг аргаар, тиймгүй бол нийлэг аргаар тус тус илтгэнэ.

Ер нь, монгол хэлний “ . . . үгийн эхэнд байрладаг язгуур нь дагавраас олон, дагавар нь нөхцөлөөс олон, нөхцөл нь дагавраасаа цөөн байдаг . . . ” (Өнөрбаян.2004.х.143)² онцлогоос үл гажин, нэр үгэлбэрийн хэлзүйн тооны айн илрэх хэрэглүүр болсон дагавар бүтээвэр нөхцөл бүтээврээсээ тоогоор арай олон байна.

2. Үгэлбэрээр илрэх байдал

Монгол хэлний нэр үгэлбэрийн хэлзүйн тооны айн илрэх нэг чухал хэрэглүүр бол хэлбэржсэн үг буюу үндэс, нөхцөл хоёроос бүтсэн үгэлбэр байна. Үүнд, нэр үгэлбэрийг нэг, аравт, хос, хориул, өрөөсөн гэх мэт тодорхой тоо заах үгэлбэр; гучаад, олон, цөөн, шахам, орчим, тоогүй, бүх, бүр, нийлбэр, бэлчир, салаа гэх мэт тодорхойгүй

² Ц.Өнөрбаян. Орчин цагийн монгол хэлний үгзүй. УБ. 2004.

тоо заах үгэлбэр гэж ангилах бөгөөд эдгээр үгэлбэр ихэнхдээ, тооны айн утгыг задлаг аргаар илтгэх хэрэглүүр болдог.

Үйл үгэлбэрийг гурвал, тавла, хосол гэх мэт тодорхой тоо заах үгэлбэр; хорш, олиш, цөөр, хор, нэм, хас, сий, салаал, нийл, эсрэгц, мөрийц, үрж, сарни, цувар, түг гэх мэт тодорхойгүй тоо заах үгэлбэр гэж ангилах ба эдгээр үгэлбэр тоо заах үг болон ганц, ганц бусыг ялгах үгтэй бол задлаг-нийлэг аргаар, тиймгүй бол нийлэг аргаар нэр үгэлбэрийн хэлзүйн тооны айн утгыг илтгэнэ. Нийлэг аргаар тооны айн утга илтгэх хэрэглүүр нь үйл үг бүтээх дагавар болдог. Эдгээр онцлогийг жишээлэн үзүүлбэл:

Нэг баавгай гарч ирэв, Өрөөсөн гутал байна гэвэл нэг, өрөөсөн гэх мэт нэр үгэлбэр тодорхой ганц тоо; Хоёр хүн ойд явж байв; Зуутын дэвсгэрт гэвэл хоёр, зуут гэх мэт нэр үгэлбэр тодорхой, ганц бус, ялгаварт бус тоо; Гуч дөчин хүн; Тавь шахам сурагч гэвэл гуч дөчин, тавь шахам гэх мэт үгэлбэр тодорхойгүй ялгаварт бус тоо тус тус илтгэж байна.

Номуудыг хоёр хоёроор хослуулан тавив; Хөзрийг тавлан холих гэвэл хослуулан, тавлан гэх мэт үйл үгэлбэр тодорхой, ганц бус, ялгаварт бус тоо; Гурвыг дөрвөдөөр үржүүлбэ; Бичиг үл мэдэгчийн тоо жилээс жилд цөөрөв гэхэд үржүүлбэ, цөөрөв гэх мэт үйл үгэлбэр тодорхойгүй, ганц бус, ялгаварт бус тоо тус тус зааж байна.

Ийнхүү монгол хэлний нэр болон үйл үгэлбэр ердийн харилцааны орчинд тодорхой ганц, ганц бус; тодорхой ганц бус ялгаварт бус, тодорхойгүй ялгаварт бус тооны утга илтгэх бөгөөд хэрэв харилцааны тухайн орчинд тодорхой ганц бус, олон цөөний ялгаварт, тодорхойгүй олон цөөний ялгаварт тооны утга илтгэх шаардлага тулгарвал тэр цагт юмын тооны олон, цөөнийг ялган тодруулах утга үүрэгтэй бүтээвэр юм уу үгэлбэр хэрэглэж, Арван түмэн их цэрэг гэхэд их хэмээх үгэлбэр хэрэглэн, олны утгыг ялган үзүүлж, тодорхой ганц бус олон тоо; Аравхан морь гэхэд -хан гэх мэт дагавраар цөөний утгыг ялган үзүүлж, тодорхой ганц бус цөөн тоо; Ирсэн хүн маш олон гэхэд маш гэх мэт бүтээврээр олны утгыг онцлон эрчимжүүлж, тодорхойгүй ялгаварт олон тоо; Оруулах газар үнэхээр цөөн гэхэд үнэхээр гэх мэт үгэлбэрээр цөөний утгыг эрчимжүүлж, тодорхойгүй ялгаварт цөөн тоо тус тус заана. Түүнчлэн, Манай суманд казах, монгол, татар, уйгур ч бий; Бид амьтны хүрээлэнд чоно, арслан, үнэг, баавгай хардаг гэх мэт жишээнд казах, монгол, татар, уйгур; чоно, арслан, үнэг, баавгай гэх мэт нэрсийг эс давтаж, эс захируулан холбож задлаг аргаар; Хүүхэд багачууд сайн уу?; Энд хэн хэн ирэв? гэдэгт хүүхэд багачууд зэрэг ойролцоо үгийг давтан хоршиж, хэн гэх мэт үгийг давтаж, эс захируулан холбож задлаг аргаар; Зуугаас тавийг хасахад тавь болно; Би энэ сарын таванд явна гэх мэт жишээнд зуу; тавь; тав зэрэг нэрийг эс давтаж, захируулан холбож задлаг аргаар; Сумын малд сайн сайн хашаа барив; Энэ хэн хэний ном бэ? зэрэг өгүүлбэрт байгаа сайн; хэн гэх мэт нэрсийг давтаж захируулан холбож задлаг аргаар; Үхэр, хонь сааж, малын ноос хярган, заримдаа хонь хариулна; Багш үлгэр ярьж, ном уншиж, зураг зурж байна гэсэн өгүүлбэрт харилцан адилгүй өгүүлэхүүнээр нэг эзний олон үйлийг үзүүлэхдээ өгүүлэхүүн болж байгаа үйл үгэлбэрийг эс давтаж, эс захируулан холбож задлаг аргаар; Үүгээр түүгээр хөлхөлдөн хөлхөлдсөөр байна; Хонь мал өсөн өссөөр байна гэх мэт жишээнд хөлхөлдөн хөлхөлдсөөр; өсөн өссөөр гэж үйл үгэлбэрийг давтаж, эс захируулан холбож задлаг аргаар; Гэрийн хажууд хуран зогсжээ; Нэг газарт бөөгнөрөн ургажээ зэрэг өгүүлбэрт үйл үгэлбэрийг эс давтаж, захируулан холбож задлаг аргаар; Адуу нь өсөн өссөөр мянган адуутан болов; Сурагчид сургуульдаа цуглан цугласаар найман цагт хичээл эхлэв гэх мэт жишээнд өсөн өссөөр гэдэг

үгэлбэрийг болов гэдэг үгэлбэртэй; цуглан цугласаар гэдэг үгэлбэрийг эхлэв гэдэг үгэлбэртэй давтан захируулж холбон, задлаг аргаар тус тус хэлзүйн тооны айн утгыг илтгэсэн байна. Эдгээр жишээнд хэлзүйн тооны айн утгыг зөвхөн харилцааны ердийн орчинд анхны байдлаар үзүүлсэн бөгөөд цаашид харилцааны орчин өөрчлөгдөн, ганц, ганц бус, ялгаварт, ялгаварт бус, олон, цөөн зэргээр ялган хэлэлцэх шаардлага тулгарахад тооны айн утгыг илтгэх аргын төрөл зүйл үл хувиран, гагцхүү тухай тухайн тооны утга илтгэх хэрэглүүр л чухалчлагддаг онцлогтой байна.

Ийнхүү, монгол хэлний хэлзүйн тооны ай хүний нийгмийн амьдралын төрөл бүрийн орчин нөхцөл дунд харилцааны хэрэглүүрийн олон талт үүрэг гүйцэтгэхдээ “... хэлзүйн утга, хэлбэр хоёрын нэгдэл...” (Өнөрбаян.2004.х. 13)³ болсон хэлзүйн аргаар илэрч, хэлзүйн доод, дээд хоёр төвшинд тус тусын аргад шүтэн биежиж бодождог онцлогтой байна. Өөрөөр хэлбэл, үгэлбэрзүйн төвшинд бол нэг үгэлбэрийн бүтцийн хүрээнд хэлзүйн утга илрүүлэх нийлэг арга; өгүүлбэрзүйн төвшинд хоёр юм уу түүнээс дээш үгэлбэрийн бүтцийн хүрээнд хэлзүйн утга илрүүлэх задлаг арга болон эдгээрийг хамтатгасан задлаг - нийлэг аргын аль алинаар илэрдэг байна. Үүнд, монгол хэлний хэлзүйн тооны ай нийлэг аргаар илрэх дагавар, нөхцөл гэсэн үндсэн хоёр хэрэглүүртэй бол задлаг арга нь нэр үгэлбэрийн тооны айн утгыг хэлбэржсэн үгс буюу үгэлбэрийн холбоонд тулгуурлан илтгэдэг байна.

Номзүй

1. П.Бямбасан.Орчин цагийн монгол хэлний үгийн бүтэц.Нэр үгсийн аймаг.УБ.1975
2. П.Бямбасан.Орчин цагийн монгол хэлний үйл үгийн байдлыг илрүүлэх задлаг аргын тухай асуудалд. УБДС.ЭШЗАБ.1986. ХХ боть.1-23 дугаар дэвтэр
3. Т.Дашцэдэн.Орчин цагийн монгол хэлний нэрийн тоо.УБ.1980
4. Ц.Өнөрбаян.Орчин цагийн монгол хэлний үгзүй.УБ. 2004
5. Хөхбарс. Монгол хэлний тэг хэлбэрээр илрэх жинхэнэ нэрийн “тоо”. Дундад Улсын Монгол хэлбичгийн шинжилгээний нийгэмлэг.ЭШӨ-ийн түүвэр.1.1988

SUMMARY

In this article, author analyzed the plural form in Mongolian. Noun plurals are not formed by the suffixes: -д, -ууд, -үүд, -нууд, -нүүд, -чууд, -чүүд, -чуул, -чүүл, -с, -нар, -нэр. In other words, the suffixes such as -д, -ууд, are not the plural suffixes.

² Ц.Өнөрбаян. Орчин цагийн монгол хэлний үгзүй. УБ. 2004.